

“Банкны төлбөрийн тэнцлийн мэдээ”-ний маягтыг нөхөх заавар

МАЯГТЫГ БӨГЛӨХӨД АНХААРАХ ЗҮЙЛС

- Банкны нэр, хаяг, регистрийн дугаарыг нөхөж бичих.
- **Банкны төлбөрийн тэнцлийн мэдээ (цаашид мэдээ гэх)** -г сар бүр гаргах бөгөөд зөвхөн тайлант хугацааны ажил, гүйлгээг маягтад тусгана.
- Маягтад өөрөөр заагаагүй бол мэдээг **мянган нэгжээр** (ам.доллар болон үндсэн валют) бэлтгэн ирүүлнэ.
- Мэдээнд орсон зарим нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

Эдийн засгийн харьяат бус /ЭЗХБ/:

- Гадаад улсад бүртгэлтэй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа гадаад улсын элчин сайдын яам, консул болон байнгын төлөөлөгчдийн газар;
- Монгол Улсын аж ахуйн нэгжийн гадаад улсад байршиж буй салбар, охин компани;
- Гадаадын иргэн (Монгол Улсад 1 жилээс дээш хугацаагаар буюу байнга оршин сууж байгаа иргэн энд хамаарахгүй);
- Гадаад оронд 1 жилээс дээш хугацаагаар буюу байнга оршин сууж байгаа Монгол Улсын иргэн (Элчин сайдын яам, консул, төлөөлөгчийн газарт ажиллагч, цэргийн албан хаагч, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, суралцагч, эмчлүүлэгч иргэн энд хамаарахгүй);

Үнэт цаас: Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, хадгаламжийн сертификат зэргийг оруулна.

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Харьяат ба харьяат бусын хооронд тодорхой нөхцөлтэйгөөр байгуулсан худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл (форвард, фьючерс, опцион, своп)-үүд болон түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгслүүдийг багтаана.

Гадаад зээл: Монгол улсын эдийн засгийн харьяат аж ахуйн нэгж (иргэн) болон эдийн засгийн харьяат бус аж ахуйн нэгж (иргэн) -ийн хооронд үүссэн урт болон богино хугацаат бүх төрлийн гадаад валютын болон төгрөгийн зээлийн үүрэг, хариуцлагыг ойлгоно. Өөрөөр хэлбэл тухайн зээлийн гэрээнд оролцогч талууд нь эдийн засгийн харьяат болон харьяат бус аж ахуйн нэгж байна.

Ханшийн болон бусад өөрчлөлт: Ам.доллараас бусад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгийн хувьд тайлант хугацааны эхний болон эцсийн ханшийн зөрүүнээс үүссэн өөрчлөлтийг “**Ханшийн өөрчлөлт**” хэсэгт, нэмж төлөгдсөн капитал, хөрөнгийн дахин үнэлгээ, үнийн өөрчлөлт, хөнгөлөлт, урамшуулал зэрэг гүйлгээ болон ханшаас бусад өөрчлөлттэй холбоотойгоор гарсан өөрчлөлтийг “**Бусад өөрчлөлт**” хэсэгт тусгана.

Бүртгэлийн арга, валютын код: Ажил, гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн **аккруэл сууриар** бүртгэнэ. Валютын кодыг ISO 4217 стандартын дагуу тэмдэглэнэ. Жишээ: USD, EUR гэх мэт.

Төлбөрийн тэнцлийн тайланг гаргахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудсанд байрлах “[Статистик](#)” цэсэнд хандаж авна уу.

ГАДААД АКТИВ

- **А.1 ЭЗХБ-ын үнэт цаасанд оруулсан танай банкны хөрөнгө оруулалт:**

Танай банкнаас эдийн засгийн харьяат бус аж ахуйн нэгжийн дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт болон бусад гадаадын банк санхүүгийн байгууллага, засгийн газар, ААН-ын гаргасан бүх төрлийн урт болон богино хугацаат үнэт цаасанд байршуулсан хөрөнгө оруулалтыг тусгана.

Танай банкнаас Монгол улсын Засгийн газар болон ААН-үүдийн олон улсад гаргасан хувьцаа ба бусад төрлийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд эдийн засгийн харьяалал нь нэг улс буюу эзэмшигч, үнэт цаас гаргагчын эдийн засгийн харьяалалд шилжилт хийгдээгүй тул энэ төрлийн ажил гүйлгээг төлбөрийн тэнцлийн мэдээнд тусгахгүй.

- **А.2 ЭЗХБ-т олгосон зээлийн эх үүсвэр:**

Танай банкнаас эдийн засгийн харьяат бус гадаадын банк, санхүүгийн байгууллага болон бусад байгууллага, иргэнд олгосон урт болон богино хугацаат, валютын болон төгрөгийн зээлийн мэдээллийг тусгана.

- **Урт хугацаат (1 жилээс дээш хугацаатай):** Гэрээнд заасны дагуу нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх зээлийг бүртгэнэ.
- **Богино хугацаат (1 жилээс доош хугацаатай):** Гэрээнд заасны дагуу нэг жил ба түүнээс доош хугацаанд төлөгдөх зээлийг бүртгэнэ.

- **А.3 ЭЗХБ банкинд байршиж буй харилцах, хадгаламж, мөн касс дах бэлэн валют:**

Танай банкнаас эдийн засгийн харьяат бус банк, санхүүгийн байгууллагад байршуулсан валютын харилцах /НОСТРО/, хадгаламж болон банкны касс дах бэлэн валютын эхний, эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг тусгана. Замд яваа бэлэн валютыг касс дах бэлэн валютын үлдэгдэлд оруулан тооцно.

Дараах төрлийн гүйлгээ, үлдэгдлийг оруулахгүй: Төв банкин дах танай банкны харилцах хадгаламжийн үлдэгдэл, түүний өөрчлөлт, харьяат банкинд байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, түүний өөрчлөлт, хадгаламжийн сертификат, түүний өөрчлөлт.

- **А.4 ЭЗХБ-т олгосон, хугацаа хэтэрсэн зээл:**

Танай банктай хөрөнгө оруулалтын хамааралгүй ЭЗХБ гадаадын банк, санхүүгийн байгууллага болон бусад байгууллагад олгосон урт болон богино хугацаат, валютын болон төгрөгийн гэрээнд заагдсан төлбөр төлөгдөх эцсийн хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийг тусгана.

ГАДААД ПАССИВ

- **Б.1 Танай банкнаас гаргасан үнэт цаасанд ЭЗХБ-аас оруулсан хөрөнгө оруулалт:**

Эдийн засгийн харьяат бусаас танай банкны дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт болон танай банкнаас гаргасан бусад бүх төрлийн урт болон богино хугацаат үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын дүнг тусгана.

- **Б.2 ЭЗХБ-аас авсан танай банкны зээлийн эх үүсвэр:**

Танай банкнаас эдийн засгийн харьяат бус гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан урт болон богино хугацаат, валютын болон төгрөгийн зээлийн мэдээллийг тусгана.

- **Урт хугацаат (1 жилээс дээш хугацаатай):** Гэрээнд заасны дагуу нэг жилээс дээш хугацаанд буцаан төлөх зээлийг бүртгэнэ.
- **Богино хугацаат (1 жилээс доош хугацаатай):** Гэрээнд заасны дагуу нэг жил ба түүнээс доош хугацаанд буцаан төлөх зээлийг бүртгэнэ.

Хоёрдогч өглөг: Тус зээлийг танай банк нь дамжуулан зээлдэх хэлбэрээр гуравдагч этгээдэд олгож, зээлийн эргэн төлөлтийг ЭЗХБ-т тухайн ААН шууд шилжүүлдэг тохиолдолд аж ахуйн нэгжийн мэдээллийг үндсэн хэсэгт тусгахгүй бөгөөд “Дамжуулан зээлдүүлсэн аж ахуйн нэгж” гэсэн баганад зөвхөн нэрийг тусгах ёстой болохыг анхаарна уу. Харин үндсэн болон хүүгийн төлбөрийг танай банк гуравдагч этгээдээс хүлээн авч харьяат бус аж ахуй нэгж рүү шилжүүлдэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн аж ахуй нэгжийн нэрийг тусгах шаардлагагүй.

- **Б.3 Танай банкин дээр байршиж буй ЭЗХБ-ын харилцах хадгаламж:**

Эдийн засгийн харьяат бус банк, санхүүгийн байгууллага, иргэд, ААН-ын зүгээс танай банкинд байршуулсан төгрөг болон валютын харилцах, хадгаламжийн эхний, эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг тусгана.

Дараах төрлийн гүйлгээ, үлдэгдлийг оруулахгүй: Харьяатын танай банкинд байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, түүний өөрчлөлт, ЭЗХБ-ын эзэмшилд буй хадгаламжийн сертификат, түүний өөрчлөлт.

- **Б.4 ЭЗХБ-аас авсан, хугацаа хэтэрсэн зээл:**

Танай банктай хөрөнгө оруулалтын хамааралгүй ЭЗХБ гадаадын банк, санхүүгийн байгууллага болон бусад байгууллагаас танай банкны авсан валютын болон төгрөгийн зээлийн гэрээнд заагдсан төлбөр төлөх эцсийн хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийг тусгана.

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

- **Цэвэр авлага /Эерэг позиц/:**

Танай банкны эдийн засгийн харьяат бустай хийсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн (форвард болон опшин) активыг бүртгэх бөгөөд хэлцлийн дүнгээр бус тайлант хугацаанд хийгдсэн хэлцлийн ханшийн зөрүүнээс олж байгаа ашиг, алдагдлын дүнг тайлант хугацаанд гарсан цэвэр өөрчлөлт хэсэгт тусгана.

- **Цэвэр өглөг /Сөрөг позиц/:**

Танай банкны эдийн засгийн харьяат бустай хийсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн (форвард болон опшин) пассивыг бүртгэх бөгөөд хэлцлийн дүнгээр бус тайлант хугацаанд хийгдсэн хэлцлийн ханшийн зөрүүнээс олж байгаа ашиг, алдагдлын дүнг тайлант хугацаанд гарсан цэвэр өөрчлөлт хэсэгт тусгана.

БАТАЛГААЖУУЛАЛТ

- Мэдээг бэлтгэсэн ажилтан болон мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулсан албан тушаалтны мэдээллийг оруулж, гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулна.
- Мэдээг бэлтгэх явцад ашигласан аливаа нэмэлт тооцооллын талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Тэмдэглэл” хэсэгт тусгана.

МОНГОЛБАНК

Судалгаа, статистикийн газрын

Статистикийн хэлтэс

Утас: 327088, 323243

Цахим хаяг: bop@mongolbank.mn